



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

20<sup>20</sup> оны 11 сарын 04 өдөр

Дугаар 8/683

Алтай хот

Г Комисс томилох тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 28.1, 28.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 317 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн автозамын сангийн хөрөнгөөр хийгдсэн АЗДТГ-2020-01 дугаар гэрээт Оргил багийн гэрлэн дохиотой гурван замын уулзвараас баруун тийш 400м 2 авто зогсоолыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор

Нарийн бичгийн дарга: М.Батсуурь -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Зураг төсөв, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд: М.Мандаххүү -аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга

Ж.Мөнхчимэг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Г.Мөнхөө -Мэргэжлийн хяналтын газрын Авто замын улсын байцаагч

Ч.Цогтбаяр -Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад


2.

- |              |  |
|--------------|--|
| Б.Балдорж    | -Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн   |
| Н.Энхтуяа    | -Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын барилга, хөрөнгө оруулалт, сууц өмчлөгчдийн холбоо хариуцсан мэргэжилтэн |
| Н.Золжаргал  | -Есөнбулаг сумын Оргил багийн Засаг дарга  |
| Н.Наранцэцэг | -“Сүндэр-Алтай” ХХК-ийн менежер  |
| Л.Очир       | -“Шадар туслагч” ХХК-ийн захирал   |

2.Авто замын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа техникийн нөхцөл, зураг төсөв, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сайтад байршуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг буртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн газар (Л.Ганхуяг)-т, автозамын байгууламжийн урсгал засвар, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар (Д.Энхчимэг), “Сүндэр-Алтай” ХХК-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ